

# Río Tinto

2012 оны 1-р сар  
[www.riotinto.com](http://www.riotinto.com)

**Бизнесийн ёсзүйн  
(авлигатай тэмцэх)  
стандарт**

## Таны зайлшгүй мэдэж байх ёстой зүйлс

### Бүгдэд хамаарах асуудал

- Рио Тинто нь ямар ч төрлийн хээл хахууль, авилгыг хориглодог.
- Давуу эрх олгох, олгохыг хөхүүлэн дэмжих үүднээс бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал олгох буюу авахыг хориглоно.
- Рио Тинто нь улс төрийн намын үйл ажиллагаанд оролцдоггүй, улс төрийн намд, улс төрчдөд төлбөр, хураамж төлдөггүй.
- Рио Тинто нь ажил хэргийн зохисгүй давуу тал эдлэх хээл хахууль, төлбөр хэмээн үзэх буяны хандив, тэтгэлгийг олгодоггүй.
- Рио Тинтогийн ажилтан бүр тус стандартын зөрчлийн талаар мэдээлэх үүрэгтэй.

### Рио Тинто группын бизнесийг удирдан явуулахад хамаарах асуудлууд:

- Сэжигтэй бүх зөрчлийг Рио Тинто мөрдөн шалгана.
- Рио Тинтогийн бүртгэл, тэмдэглэл үнэн зөв байна.
- Авилгад өртөх өндөр эрсдэл бүхий албан тушаалын ажилтнуудыг сургалтад хамруулж, тус стандартыг зөрчих эрсдэлийг бууруулна.
- Рио Тинто нь бүхий л бизнестээ энэ стандарттай ижил төстэй авилгатай тэмцэх стандартыг баталж, хэрэгжүүлнэ.

## Агуулга

<b>Таны зайлшгүй мэдэж байх ёстой зүйлс</b>	<b>2</b>
<b>Танилцуулга</b>	<b>3</b>
<b>Группын ёс зүйн болон эрх зүйн үүрэг хариуцлага</b>	<b>4</b>
<b>Ерөнхий нэр томьёо</b>	<b>4</b>
<b>Хэсэг А – Бүгдэд хамаарах асуудал</b>	<b>6</b>
1.0 Хахууль, авилга, бусдыг заналхийлэх	6
2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал олгох	6
3.0 Улс төрийн оролцоо	13
4.0 Буяны хандив, тэтгэлэг	14
5.0 Хээл хахууль, авилга, зөрчлийг мэдээлэх нь	15
<b>В ХЭСЭГ– Группын бизнесийн менежментийн цаашдын асуудал</b>	<b>15</b>
6.0 Удирдах түвшинд мэдээлэх, мөрдөн шалгах	15
7.0 Группын бүртгэл, тооцоо, дотоод хяналт	16
8.0 Эрх зүйн зөрчлийн эрсдэлийг бууруулах сургалт	16-17
9.0 Бизнесийн түншлэлийн харилцаа	17

## Танилцуулга

<b>Энэ юуны тухай стандарт вэ?</b>	Рио Тинто групп бүрийн бизнесийн эрх зүйн даган мөрдөх хөтөлбөртөө тусгах ёстой албан шаардлагыг тус Стандартад тусгасан бий.
<b>Энэ стандартыг хэн мөрдөх вэ?</b>	Рио Тинто группын энэхүү стандартыг бүх группын бизнес, ажилтнууд, үндсэн гэрээлэгчид (зөвлөхүүд болон бусад үйлчилгээ үзүүлэгчид мөн орно) дагаж мөрдөнө. Стандартыг мөрдөхгүй бол гэрээг цуцлах хүртэл сахилгын арга хэмжээ авна. Иргэний болон эрүүгийн хариуцлага ногдуулж болно.
<b>Хэрвээ би энэ стандартыг мөрдсөний улмаас бид бизнесийн алдагдалд орвол яах вэ?</b>	Рио Тинто нь тус стандартыг даган мөрдөж буй ажилтнууд, үндсэн гэрээлэгчдээ бүрэн дүүрэн дэмжиж ажиллана. Энэ стандартыг зөрчсөн үйлдэл хийхээс татгалзсанаар бид бизнесийн алдагдалд хүрсэн ч тухайн ажилтан, үндсэн гэрээлэгч хохирч үлдэхгүй.  Энэ стандарт нь тухайн улсын хууль тогтоомжоос өөр бол Рио Тинто аль хатуу нөхцөл, шаардлагатайг нь дагаж мөрдөнө.
<b>Энэ стандарт хэзээнээс эхэлж хэрэгжих вэ?</b>	Эрхзүйн албаны дарга өөрөөр заагаагүй бол тус стандарт 2012 оны 1-р сарын 01-ээс эхлэн хүчин төгөлдөр болно.
<b>Энэ стандартын эзэмшигч нь хэн бэ?</b>	Рио Тинтогийн эрх зүйн хэрэгжилтийг хангах алба.

<b>Энэ стандартад хэн хариуцлага хүлээх вэ?</b>	Групп бүрийн гүйцэтгэх удирдлага тус стандартыг тухайн группын ажил хэрэгт мөрдөн хэрэгжүүлнэ.
<b>Би хаанаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болох вэ?</b>	Группын ажил хэрэгт ашиглагдах маягт, зааварчилгааг Авлигатай тэмцэх арга хэрэгслийн багцад тусгасан бий. Эрхзүйн багцыг Мэдээллийн нэгдсэн санд (Эрхзүйн талаарх хуудас)-д байршуулсан бий.  Хэрвээ та ямарваа үйлдэл нь тус стандарт, холбогдох хууль тогтоомжид нийцэх эсэх талаар асуух зүйл байвал шууд удирдлагадаа буюу Рио Тинтогийн Эрхзүйн албанд хандана уу. Холбоо барих хүмүүсийн нэр, хаягийг Мэдээллийн нэгдсэн санд (Эрхзүйн талаарх хуудас)-д заасан бий.  Тус стандарт, түүнийг дагалдах барим бичигт өгөх санал байвал <a href="mailto:compliance6@riotinto.com">compliance6@riotinto.com</a> хаягаар е-мэйл илгээнэ үү.
<b>Нэртомьёо</b>	Зөвхөн нэг хэсэгт ашигласан нэртомьёог тус хэсгийн эхэнд оруулсан бий. Харин нэгээс илүү хэсэгт ашигласан нэртомьёог Нэртомьёоны хэсгээс үзнэ үү.

## Группын ёс зүйн болон эрх зүйн үүрэг хариуцлага

Шударгаар ажиллах, хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах Рио Тинтогийн үүрэг хариуцлагыг “Бидний ажилладаг арга барил”-д тодорхойлсон бий.

**“Рио Тинто компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй хүн бүхэн шударгаар ажиллах үүрэг хүлээнэ... Рио Тинто үйл ажиллагаа явуулж буй орон бүрт бүх ажилтан нь тухайн улсын хууль, Бидний ажилладаг арга барил, Рио Тинтогийн бусад бодлого, стандартыг баримталж ажиллах үүрэгтэй. Хуулийг мэдэхгүй байх нь түүнийг биедүүлэхгүй байх бодит шалтгаан болохгүй. Иймээс бид бүгдээрээ өөрийн ажилтай холбогдолтой хуулийг мэддэг байх ёстой.”**

Бидний үндсэн үнэт зүйлээс улбаалан энэ үүрэг хариуцлага гарч ирж буй юм. Энэ үүрэг хариуцлагыг хүлээнээр бид ажил олгогч болон туншээр сонгогдох боломжтой. Энэ үүрэг нь бидэнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тусалдаг бөгөөд бидэнд урт хугацаанд бизнесээ амжилттай явуулахад нэн чухал юм.

Энэ үүрэг амлалтыг дэмжих, шударга байдал, хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах хүчирхэг, ил тод соёлыг бий болгохын тулд бид группын хэмжээнд дагаж мөрдөх Бизнесийн ёс зүйн хэм хэмжээ, Хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү Бизнесийн ёсзүйн (авлигатай тэмцэх) стандарт нь тэрхүү хөтөлбөрийн гол хэсэг юм.

## Ерөнхий нэр томьёо

**Нэгдмэл сонирхолтой этгээд** гэдэгт дараах орно. Үүнд:

- хувийн бизнесийн үйл ажиллагаа хамтран явуулж буй хүн;
- дотны найз, анд;
- үндсэн ажилтан, үндсэн гэрээлэгч үр ашгийг нь хүртэх өмчийг эзэмшихээр итгэмжлэгдсэн этгээд ;
- ажилтан, үндсэн гэрээлэгчийг удирддаг компани буюу өөр байгууллагын захирал, ажилтан

**Үндсэн гэрээлэгч** гэдэг нь “1-р ангиллын гэрээлэгч” болох гэрээлэгч, зөвлөх, өөр бусад үйлчилгээ үзүүлэгчид, группийн зүгээс эрх зүйн хэрэгжилтийн сургалтанд хамрагдах шаардлагатай гэж тодорхойлсон бусад этгээд

**ТАЙЛБАР:**

Энэхүү нэр томьёог *Авлигатай тэмцэх удирдамжид* тусгасан бий.

**Гэрээлэгч** гэдэгт ямар нэг агентлаг, компаниар дамжуулан түр хугацаагаар хөлсөлж буй хувь хүнийг хэлнэ.

**Ажилтан** гэдэгт Рио Тинто группын захирал, ажилтан, ажилчид ( байнгын, түр, бүтэн болон хорогдуулсан цагаар ажилладаг) болон групптэй шууд гэрээ байгуулсан түр ажилтнуудыг ойлгох бөгөөд гэрээлэгчид үүнд хамаарахгүй.

**Группын бизнесийн /Хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр** гэж Хуульд нийцэж ажиллах стандартад заасан шаардлагыг хангасан Группын бизнесийн Хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах хөтөлбөрийг хэлнэ.

## Ерөнхий нэр томьёо (үргэлжлэл)

**Төрийн албан хаагч** гэдэгт дараах хамаарна. Үүнд:

- төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагч;
- төрийн агентлаг, зохицуулах байгууллагын ажилтан, албан хаагч;
- улс төрийн намын ажилтан, албан хаагч буюу улс төрийн сонгуульд нэр дэвшигч;
- НҮБ, Дэлхийн банк, Олон улсын валютын сан гэх мэт олон улсын байгууллагын ажилтан, албан хаагч;
- шүүх, эрх мэдлийн байгууллагын гишүүн буюу Дээд шүүхийн гишүүн;
- томилгооны албан тушаалтан, ёс заншил болон гэрээний дагуу бий болсон албан тушаал хашиж буй хааны гэр бүлийн зарим гишүүд, зарим отог овгийн тэргүүн;
- төрийн албан хаагчийн эрх бүхий зуучлагч буюу зуучлагч гэгдэх хүн;
- төрийн ийм албан хаагчийн хамаатан буюу нэгдмэл сонирхолтой этгээд .

ТАЙЛБАР:

- а) “Төрийн албан хаагч” гэдэгт цагдаа, гаалийн болон татварын байгууллагын ажилтнууд, төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ажилтнууд, улс төрийн намын ажилтнууд, түүнчлэн төрийн албан хаагч, улс төрийн намын ажилтнуудын хүүхдүүд, бусад хамаатан садан орно.
- б) Хэн нэгнийг төрийн албан хаагч мөн эсэх, аж ахуйн нэгжийг төрийн өмчийн байгууллага мөн эсэх талаар эргэлзэж байгаа бол та Рио Тинтогийн Эрх зүйн албатай зөвлөлдөнө үү.

Группын бизнес гэдэгт дараахийг багтаан ойлгоно. Үүнд:

- Рио Тинтогийн бүтээгдэхүүн хариуцсан групп;
- Группын гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллаж буй албад.

**Группын гүйцэтгэх удирдлага** гэдэг нь бүтээгдэхүүн хариуцсан группын гүйцэтгэх ерөнхий удирдлагыг хэлэх бөгөөд глобал чиг үүргийн хувьд бол Рио Тинтогийн Гүйцэтгэх хорооны гишүүдийг хэлнэ.

**Дотоод хяналт** гэдэгт Бидний ажилладаг арга барил, бодлого, стандарт болон эрх зүйн үүргийг биелүүлэх, эрх зүйн шинж чанартай эрсдэлийг зохицуулахад зориулж боловсруулсан өөр бусад дотоод хяналтын арга хэрэгслийг хэлнэ.

**Нэрлэсэн улс** гэдэг нь Транспаренси интернэшнэл байгууллагаас хамгийн сүүлд гаргасан авилгад өртсөн индексээр 6.5-аас илүүгүй оноо авсан улсыг хэлнэ.

**Хамаатан садан** гэдэг нь гэр бүлийн гишүүнийг, тэр дундаа эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, үр хүүхэд, цусан төрлийн холбоогоор, гэрлэлтээр буюу үрчлэлтээр садан төрлийн холбоо үүссэн хүмүүс (худ ургийн хүмүүс орно) болон тухайн хүний гэрт нь амьдарч буй хүнийг (түрээслэгч, гэрийн ажилтан зэргээс бусад) хэлнэ.

**Рио Тинто, Рио Тинто Групп буюу Групп** гэдэгт Рио Тинто plc, Рио Тинто лимитэд болон тэдгээрийн бүхэлд нь болон дийлэнхийг нь шууд ба шууд бус байдлаар эзэмшдэг буюу удирддаг аливаа бизнесийг хэлнэ.

ТАЙЛБАР:

Рио Тинто plc, Рио Тинто лимитэд аль нь ч дийлэнхи хувьцааг нь эзэмшдэггүй учир Куинсланд Люмина лимитэд зэрэг аж ахуйн нэгж энэ нэртомьёонд хамаарахгүй. Хэрвээ та аливаа аж ахуйн нэгжийг Рио Тинто групп-т хамаарах эсэх талаар эргэлзэж байгаа бол Рио Тинтогийн хуулийн хэлтэст хандан зөвлөгөө авна уу.

**Рио Тинтогийн ажилтнууд** гэдэг нь Рио Тинтогийн албан хаагчид, үндсэн гэрээлэгчдийг хэлнэ.

## Хэсэг А – Бүгдэд хамаарах асуудал

### 1.0 Хахууль, авилга, бусдыг заналхийлэх

*Рио Тинто нь бүхий л төрлийн хахууль, авлигыг хориглодог.*

Тус хэсэгт дараах нэртөмьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

**Үйл явцыг хялбаршуулах урамшуулал** гэдэг нь тухайн хувь хүн, компанид үзүүлэх үйлчилгээг баталгаажуулах, явцыг нь түргэтгэх үүднээс төрийн албан хаагчид (бага тушаалын) өгсөн албан бус урамшууллыг (ихэвчлэн бага хэмжээтэй) хэлэх бөгөөд үүнийг Групп хориглодог.

#### Хээл хахуулийг хориглоно.

Рио Тинтогийн ажилтнууд хээл хахууль, авилга өгөх, хүлээн авах, түүнд оролцохыг хориглоно.

Та бизнестэй болох, түүнийгээ хадгалж үлдэх, чиглүүлэх, бизнесээ явуулахад давуу тал эдлэх зорилгоор аливаа хээл хахууль буюу өөр бусад зохисгүй давуу тал эдлэхийг шууд болон шууд бус байдлаар санал болгох, амлах, эдлүүлэх, түүнчлэн давуу тал эдлүүлэхийг шаардах болон хүлээн авах ёсгүй. Энэ нь төрийн болон хувийн байгууллага, хувь хүнтэй холбогдох харилцаанд хамаарна.

**Үйл явцыг хялбаршуулах урамшууллыг хориглоно.** Рио Тинтогийн ажилтнууд нь төрийн албан хаагчдад шууд болон шууд бус байдлаар үйл явцыг хялбаршуулах урамшууллыг санал болгох, өгөхийг хориглоно.

**Энэ стандартад зааснаас бусад урамшууллыг төрийн албан хаагчдад хэзээ ч төлж болохгүй.** Рио Тинтогийн ажилтнууд нь энэ стандартад зааснаас бусад урамшууллыг төрийн албан хаагч хүнд төлж болохгүй.

#### ТАЙЛБАР:

Авилгатай тэмцэх удирдамжид төрийн албан хаагчдад өгөх хууль ёсны урамшууллыг заасан бий.

**Аюулгүй байдлаа хамгаалах үүднээс төлбөр төлж болно.** Хувь хүний аюулгүй байдалд ил, далд байдлаар заналхийлж, төлбөр шаардсан бол Рио Тинтогийн ажилтнууд төлбөр өгч болох бөгөөд үүнээс бусад тохиолдолд ийм төлбөрийг хориглоно. Ийм тохиолдолд Группын үйл ажиллагааны хувьд тус төлбөрийг:

- Рио Тинтогийн санхүүгийн бүртгэл мэдээлэлд хувь хүний аюулгүй байдлыг хангахаар хийсэн сүрдүүлгийн төлбөр гэж бүртгэн оруулна.
- холбогдох Группын гүйцэтгэх удирдлага, Эрх зүйн албаны дарга, аюулгүй байдлын албаны дарга нарт аль болох түргэн мэдэгдэнэ.

### 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал олгох

*Давуу эрх олгосны урамшуулал буюу шагнал болгож бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал өгөх, авахыг хориглоно.*

Тус хэсэгт дараах нэртөмьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

**Урамшуулал** гэдэг нь бэлэг сэлт, зугаа цэнгэл, аяллыг хэлнэ.

#### ТАЙЛБАР :

Энэ нэртөмьёонд томилолтын зардал хамаарахгүй.

**Улсад тогтоосон хэмжээ** гэдэг нь Мэдээллийн нэгдсэн сан (Эрхзүйн талаарх хуудас) -гийн Авилгатай тэмцэх хуудсанд үзүүлсэн, улс оронд тогтоосон хэмжээг хэлнэ.

**Зугаа, цэнгэл** гэдэгт Рио Тинтогийн үйл ажиллагааг сурталчлах, үзүүлэн харуулах, хэлэлцэхтэй холбоотой хоол (хэт тансаг биш) хамаарахгүй.

**Зардлын удирдлагын систем** гэдэг нь Группын үйл ажиллагаанд ашиглаж, ажилтнуудын зардлын нэхэмжлэлийг шийдвэрлэдэг системийг хэлнэ.

**Бэлэг сэлт** гэдэг нь авсан хүн нь зах зээлийн бодит үнийг төлөлгүйгээр хүлээн авсан, өгсөн тодорхой үнэ бүхий зүйлийг хэлнэ.

**Томилолтын зардал** гэдэг нь Рио Тинтогийн ажил хэргийн уулзалт, арга хэмжээнд оролцоход гуравдагч талд учрах аялал, хоол, байр, бусад бодит зардлын төлбөрийг (хоноогоор тооцдог) хэлнэ.

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

### Урамшууллын товч хүснэгт

Үнэ өртөг (өөр бусад бүх шаардлагыг хангасан нөхцөлд)	Бүртгэх эсэх?	Урьдчилан батлуулах шаардлагатай эсэх?
<b>Нэрлэсэн үнэ өртөг**</b>	Үгүй	Үгүй
<b>&lt; улсад тогтоосон хэмжээ</b>	Тийм	Үгүй
<b>&gt; улсад тогтоосон хэмжээ</b>	Тийм	Тийм; Менежерээр
<b>&gt; 2 х улсад тогтоосон хэмжээ</b>	Тийм	Тийм; С болон түүнээс дээгүүрх зэргийн албан тушаалтан

\*\*Улсад тогтоосон хэмжээнээс 25%-иар бага. Доорхи 2..5 дах хэсгийг үзнэ үү.

#### ТАЙЛБАР :

Улс орон бүрт төрийн албан хаагч, бусад гуравдагч этгээдийн хувьд тус тусад нь хэмжээ тогтоосон байдаг. 2.7-р хэсгийг үзнэ үү.

### 2.1 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялалыг хээл хахууль гэж үзэж болно.

Бизнестэй болох, түүнийгээ хадгалж үлдэх, чиглүүлэх, бизнесээ явуулахад давуу тал эдлэх зорилгоор бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардлыг шууд болон шууд бус байдлаар өгөх, авахыг хориглоно.

**Аливаа урамшуулал нь гуравдагч этгээдийн захирагдах хууль, бодлогоор зөвшөөрөгдсөн байх ёстой.** Тухайн улсын хууль тогтоомж, гуравдагч этгээдийн ажил олгогчийн бодлогоор хориглосон урамшууллыг Рио Тинтогийн ажилтан гуравдагч этгээдэд амлах, санал болгох, өгөхийг хориглоно. Мөн адилаар тэд тухайн улсын хууль тогтоомж, гуравдагч этгээдийн ажил олгогчийн бодлогоор хориглосон аливаа урамшууллыг хүлээн зөвшөөрч, авч болохгүй.

**Бэлэн мөнгө хэзээ ч бүү өг.** Та зугаа цэнгэл, аяллын оронд, эсхүл бэлэг сэлтийн хэлбэрээр бэлэн мөнгө буюу бэлэн мөнгөтэй дүйцэхүйц зүйлийг (бэлэгний карт, сертификат, купон гэх мэт) өгч болохгүй.

#### ТАЙЛБАР:

Бэлэн мөнгө өгөх заншил тогтсон (Японд оршуулганд зориулж гэх мэт) маш ховор тохиолдол байдаг. Үүнийг С (Ерөнхий захирал/ ерөнхийлөгч) болон түүнээс дээгүүрх зэргийн албан тушаалын холбогдох менежерээр урьдчилж батлуулах ёстой.

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

**Гуравдагч талд** таны амласан, санал болгосон буюу гуравдагч талаас авахыг зөвшөөрсөн, хүлээн авсан бүх урамшуулал дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- үндсэн ажилтан буюу үндсэн гэрээлэгчийн нэр дээр бус Рио Тинтогийн нэрээр өгсөн, авсан байх;
- хэлбэр/төрөл болоод үнэ өртөгийн хувьд тухайн улс орондоо зохих цаг хугацаа, улирал, нөхцөл байдалд өгч, авч заншсан байх;
- ил тодоор өгч, авах;
- 12 сарын дотор 3-аас илүү урамшуулал нэг хүнд өгөхгүй байх, нэг хүнээс авахгүй байх.

### ТАЙЛБАР:

Гуравдагч талаас хэсэг ажилтнуудад эсхүл үндсэн гэрээлэгчдэд урамшуулал санал болговол тус Стандартад заасны дагуу тухайн хэсэг ажилтнуудын хамгийн өндөр албан тушаалтан зөвшөөрөл хүснэ.

**Гуравдагч талын зугаа цэнгэл.** Танаас гуравдагч талд амласан, санал болгосон, эдлүүлсэн бүх зугаа цэнгэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зугаа цэнгэл эдлүүлж буй Группын ажилтан, үндсэн гэрээлэгч гэх мэт Рио Тинтогийн төлөөлөгчийг байлцуулах;
- Гэрээ байгуулах, үйлдэх буюу Рио Тинтогийн үйл ажиллагааг энгийнээр сурталчилсан, үзүүлэн таниулсан, тайлбарласан байх
- Дараах хүмүүст зориулсан байвал:
  - төрийн албан хаагчид, болон
  - бусад гуравдагч этгээдэд эдлүүлж буй томоохон зугаа цэнгэлийн (тасалбар нь үнэтэй, олноц муутай спорт, соёлын арга хэмжээний урилга, тухайлбал теннисийн тэмцээн эсвэл Дэлхийн цомын төлөө тэмцээний шигшээ тоглолт, концерт шоуны нээлтийн тоглолт гэх мэт) хувьд

Дараах баримт бичгийг урьдчилан бэлтгэнэ. Үүнд:

- а) Рио Тинтогийн г зугаа цэнгэлийн арга хэмжээнд оролцуулж байгаа ажилтны ажил олгогчид танилцуулсан, бичгээр үйлдсэн урилга.
- б) Урилгыг хүлээн авахыг зөвшөөрсөн тухай ажил олгогчийн бичгээр үйлдсэн мэдэгдэл.

**Гуравдагч талд зориулсан аялал.** Гуравдагч этгээдийг аялуулсан, аялуулахаар амласан, санал болгосон (үүнд байрлах байр, холбогдох бусад зардал хамаарна) тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- гэрээ байгуулах, түүнийг гүйцэтгэх буюу Рио Тинтогийн ажил хэргийг нийтлэг байдлаар сурталчилсан, үзүүлэн таниулсан, тайлбарласан байх
- зохих хүмүүсийг хамарсан байх ;
- Дараах хүмүүст зориулсан байвал:
  - төрийн албан хаагчид,
  - Гуравдагч этгээдийн муж, улс дамнасан болон олон улсын аялал бол

Дараах баримт бичгийг урьдчилан бэлтгэнэ. Үүнд:


- а) Рио Тинтогийн арга хэмжээнд оролцуулж байгаа ажилтны ажил олгогчид мэдэгдсэн бичгээр үйлдсэн урилга.
  - б) Урилгыг хүлээн авахыг зөвшөөрсөн тухай ажил олгогчийн бичгээр үйлдсэн мэдэгдэл.
- Рио Тинтогийн адил түвшний ажилтнуудад зөвшөөрөгдөх хэмжээнээс илүүгүй байх;
  - Хүлээн авагчийн хамаатан садан, хамтрагч болон бусад зочдын аяллыг (байрыг) хамруулахгүй байх;
  - төлбөрийг нь хийсэн эсвэл нөхөн төлсөн замдаа зогссон зардлыг оруулахгүй.

### ТАЙЛБАР:

Төрийн албан хаагч болоод ажилтан ирэх 12 сарын хугацаанд танаатай хобоотой шийдвэр гаргах бол тус стандартын 2.2-р хэсэгт заасны дагуу та урьдаар Менежерээр (С буюу түүнээс дээгүүрх зэргийн албан тушаалтан) батлуулаагүйгээр тухайн ажилтанд урамшуулал олгож болохгүй.

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

### 2.2 Урамшууллыг хэзээ батлуулах шаардлагатай вэ?



Тус стандартын 2.2 хэсэгт заасан урамшуулалд шаардлагатай зөвшөөрлийг дээрхи графикт үзүүлээ

**Батлуулах шаардлагагүй:** Хэрэв 2.1 хэсэгт заасан **бүх** дүрэм журмыг биелүүлсэн, урамшууллынх нь үнэ өртөг тухайн улсад тогтоосон хязгаарлалтай тэнцүү, эсхүл бага бол **энэ журмын дагуу** та Менежерээр урьдчилан батлуулах шаардлагагүй.

**ТАЙЛБАР:**

Хэдийгээр тус стандартаар урьдчилан батлуулах шаардлага тавиагүй ч Группын зүгээс танд биелүүлэх ёстой шаардлага тавьж болно.

**Менежерээр урьдчилан батлуулах:** Хэрэв 2.1 хэсэгт заасан **бүх** дүрэм журмыг биелүүлсэн, урамшууллынх нь үнэ өртөг тухайн улсад тогтоосон хязгаарлалтаас давсан боловч тус хэмжээг 2 –оор уржүүлсэнээс бага бол тухайн урамшууллыг өгөх, авах Рио Тинтогийн ажилтан Менежерээр урьдчилан батлуулах шаардлагатай.

**С болон түүнээс дээгүүрх зэргийн (ерөнхий захирал/ерөнхийлөгч) албан тушаалтнаар урьдчилан батлуулах:** Хэрвээ стандартын 2.1 хэсэгт заасан **бүх** дүрэм журмыг **биелүүлээгүй буюу** урамшууллынх үнэ өртөг нь тухайн улсад тогтоосон хязгаарлалтаас 2 дахин буюу түүнээс ч их бол урамшуулал өгөх, авах Рио Тинтогийн ажилтан С болон түүнээс дээгүүрх зэргийн (ерөнхий менежер буюу ерөнхийлөгч) холбогдох менежерээрээ урьдчилан батлуулна .

**ТАЙЛБАР:**

- а) **Урьдчилсан зөвшөөрлийг бичгээр авах ёстой (е-мэйл хамаарна).**  
Урамшууллыг амлах, санал болгох, өгөхөөсөө өмнө бичгээр зөвшөөрөл авна. Боломжтой бол Рио Тинтогийн ажилтан урамшууллыг хүлээж авахаас **өмнө** батлуулах ёстой, хэрэв ийнхүү өмнө нь батлуулах боломжгүй бол аль болох түргэн хугацаанд батлуулна.
- б) **Хээл хахууль, хээль хахууль байж болох аливаа урамшууллыг батлах эрх хэнд ч байхгүй – стандартын 2.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг үзнэ үү.**

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

### 2.3 Гуравдагч талд олгох томилолтын зардал

#### ТАЙЛБАР:

- а) Томилолтын зардлыг нөхөн олгох явдлыг тусгайлан авч үзнэ. Рио тинто ийм төлбөрийг урамшуулдаггүй. Гэхдээ хязгаарлагдмал нөхцөл байдалд ийм төлбөр хийхийг зөвшөөрдөг.
- б) Томилолтын зардлын бүх төлбөр тооцоог тусад нь бүртгэх ёстой. Үүнийг зөвхөн зардлын удирдлагын системээр шийдэж болохгүй.

#### Гуравдагч талд олгох томилолтын зардал нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- зүй бусаар бизнестэй болох, түүнийгээ хадгалж үлдэхээр буюу давуу талтай болоход нөлөөлөх зорилгоор гуравдагч талд олгоогүй байх;
- тухайн улсын хууль тогтоомж, гуравдагч талын ажил олгогчийн нийтэд мэдэгдсэн бодлогоор зөвшөөрөгдсөн байх;
- хэлбэр/төрөл болоод үнэ өртөгийн хувьд тухайн улс орондоозаншил болж тогтсон байх;
- ил тод өгч, авах;
- томилолтын зардал хүлээн авч буй хүний ажил олгогч бичгээр зөвшөөрсөн байх;
- Хүлээн авагчийн хамаатан садан, нэгдмэл сонирхолтой этгээд, бусад зочдын зардлыг хамруулахгүй байх;
- Рио Тинтогоос өөр бусад хэлбэрээр давхардуулж төлөгдөөгүй байх;
- Гэрээ байгуулах, үйлдэхтэй холбоотой байх, эсхүл Рио Тинтогийн үйл ажиллагааг нийтлэг байдлаар сурталчилсан, үзүүлэн таниулсан, тайлбарласан байх;
- тухайн улсад тогтоосон хязгаарлалттай тэнцүү эсхүл түүнээс бага үнэ өртөгтэй байх.

#### Гуравдагч талд олгох томилолтын зардлыг заавал батлуулах шаардлагатай.

Хэрэв төрийн албан хаагчаас бусад хүнд дээрх бүх шаардлагыг хангасан томилолтын зардал олгох бол та урьдчилан Менежерээр батлуулах ёстой. Төрийн албан хаагчдын хувьд та С болон түүнээс дээгүүрх зэргийн (ерөнхий захирал/ ерөнхийлөгч) албан тушаалтнаар урьдчилан батлуулах ёстой.

#### ТАЙЛБАР:

- а) **Томилолтын зардлыг** амлах, санал болгох, өгөхөөсөө **өмнө** бичгээр батлуулсан, (емэйл байж болно) байх шаардлагатай.
- б) “Төрийн албан хаагч” гэдэгт төрийн өмчийн аж ахуй нэгжийн ажилтнууд хамаарахыг анхаарна уу.
- с) Хээл хахууль, хээль хахууль байж болох аливаа томилолтын зардлыг батлах эрх хэнд ч байхгүй – стандартын 2.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг үзнэ үү.

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

### 2.4 Томилолтын зардал олгох саналыг хүлээн авсан Рио Тинтогийн ажилтан үүнийгээ батлуулах шаардлагатай.

Дараах зөвшөөрлийг урьдчилан бичгээр авалгүйгээр Рио Тинтод хашдаг албан тушаалдаа Та, таны төрөл садан, нэгдмэл сонирхолтой этгээдийн аль нь ч гуравдагч талаас томилолтын зардал хүлээн авч болохгүй:

- томилолтын зардлын хэмжээ нь тухайн улсад тогтоосон хязгаараас бага бол менежерээсээ, эсхүл
- өөр бусад тохиолдолд С буюу түүнээс дээгүүрх зэргийн (ерөнхий захирал/ ерөнхийлөгч) албан тушаалтнаас

### 2.5 Та урамшуулал болон томилолтын зардлыг бүртгүүлэх ёстой.

Өртөг багатай л биш бол гуравдагч талд өгсөн, гуравдагч талаас авсан бүх урамшууллыг та Группын бүртгэл тооцоонд үнэн зөвөөр бүртгэх ёстой. Бүх томилолтын зардлыг Группын бүртгэл тооцоонд үнэн зөвөөр бүртгэн тусгана.

#### ТАЙЛБАР:

Өртөг багатай урамшууллын жишээг Авлигатай тэмцэх удирдамжид заасан бий. Ер нь тухайн улсад тогтоосон хязгаарлалтын хэмжээний 25%-иас бага үнэтэй зүйлийг өртөг багатайд

#### Бүртгүүлэхдээ дараах дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. Үүнд:

- бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардлын аль нь болох;
- шинж чанар, зорилго;
- өгсөн, авсан огноо;
- урамшууллын тоо хэмжээ/үнэ өртөг (хүлээн авагчийнхаар), томилолтын зардлын хувьд тооцоо хийсэн үндэслэл;
- Рио Тинтогийн бус авсан, өгсөн хүний статус – бизнес аж ахуйн нэгж/хувь хүн/төр/ төрийн байгууллага/албан хаагч;
- Рио Тинтогийн өгсөн, авсан хүний дэлгэрэнгүй мэдээлэл – бүтэн нэр, албан тушаал, хэлтэс, бизнес аж ахуйн нэгж/төрийн байгууллага

#### Менежерээр урьдчилан батлуулах шаардлагатай урамшуулал болон томилолтын зардлын төлбөрийг бүртгүүлэхэд дараах шаардлагатай. Үүнд:

- сүүлийн 12 сарын хугацаанд Рио Тинтогийн бус хүнд өгсөн, авсан өөр бусад урамшууллын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- тус стандартаар шаардсан зөвшөөрлийн хуулбар;
- тухайн хүн сүүлийн 12 сарын хугацаанд мөн ирэх 12 сарын хугацаанд оролцсон буюу оролцохоор төлөвлөж буй Рио Тинтотой хамаатай арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

## 2.0 Бэлэг сэлт, зугаа цэнгэл, аялал, томилолтын зардал (үргэлжлэл)

Групп нь хүдээн авсан, өгсөн урамшуулаа зардлын удирдлагын системд эсхүл тухайн зорилгоор ашигладаг бүртгэлийн системд бүртгэж болно. Томилолтын зардлыг тухайн зориулалтаар ашигладаг бүртгэлийн системд оруулна. Тус бүртгэл нь группын бүртгэл тооцооны нэг хэсэг болно.

### ТАЙЛБАР:

- a) Авлигатай тэмцэх удирдамжид бүртгэлийн маягтыг оруулсан бий.
- b) Зардлын удирдлагын системд оруулсан ажилтнуудын авсан, өгсөн бүх урамшуулын бүртгэл, мэдээллийг бүрэн баримтжуулна. Тухайлбал, урьдчилан батлуулсан болон шаардлагатай холбогдох бусад баримт бичиг (бүх баримт, нэхэмжлэл, төлбөрийн баримт гэх мэт) зэргийг бүрдүүлнэ.

### 2.6 Бэлэг сэлт, зугаа цэнгэлийн үнэ өртөгийг тодорхойлох нь

Дараахийн аль ихээр нь бэлэг сэлтийн үнэ өртөгийг тооцно. Үүнд:

- бодит үнэ (тухайн бэлгийг ямар үнээр худалдаж авсан гэх мэт);
- тухайн бэлгийн зах зээлийн бодит үнэ (тухайн бэлгэнд бодитоор сэтгэдэг хүн ямар үнэ төлөх гэх мэт).

Зугаа цэнгэлийн үнэ өртөгийг гаргахдаа зугаа цэнгэлийн нийт бодит үнийг тухайн зугаа цэнгэлд оролцсон хүний тоонд хувааж гаргана.

### ТАЙЛБАР:

Хэрэв бэлэг сэлт, зугаа цэнгэлийн зардлыг гуравдагч тал төлсөн, зардлын хэмжээ тодорхойгүй бол үндэслэлтэй тооцоо хийж үнэ өртөгийг нь гаргана.

### 2.7 Тухайн Улсад тогтоосон хязгаарлалт

Тухайн улс орныг хариуцсан Группын гүйцэтгэх удирдлага, Эрх зүйн алба нь тухайн улс орны түвшинг тогтооно.

- Группын гүйцэтгэх удирдлага нь эдгээр тогтоосон хязгаарлалтын талаар тухайн улс дах холбогдох ажилтнууд, үндсэн гэрээлэгчдэд мэдээлнэ.
- Эрхзүйн алба нь эдгээр хэмжээг Мэдээллийн нэгдсэн сангийн (Эрхзүйн талаарх хуудас) Авлигалын талаарх хуудсанд бүртгэн оруулна.

### ТАЙЛБАР:

- a) Төрийн албан хаагч болоод бусад гуравдагч этгээдэд хамаарах хязгарлалтыг улс бүрт тогтооно.
- b) Тухайн улсад хязгаарлалт тогтоогоогүй бол Мэдээллийн нэгдсэн сан (Эрх зүйн талаарх хуудас) дах тогтсон хязгаарлалтын хэмжээг даган мөрдөнө.
- c) Рио Тинтогоос ирж ажиллаж буй ажилтнуудад тухайн улсад тогтоосон хязгаарлалт хамаарна.
- d) Тус стандартын дагуу ямар ч групп тухайн улс дах үндсэн ажилтнууд, үндсэн гэрээлэгчдэд хязгаарлалтаас доогуур хэмжээ тогтоохыг хориглоогүй. Энэ тохиолдолд бууруулсан хэмжээний талаар холбогдох ажилтнууд, үндсэн гэрээлэгчдэд байнга, тогтмол мэдээлж, Эрхзүйн албаны даргад мэдэгдэнэ.

### 3.0 Улс төрийн оролцоо

**Рио Тинто нь улс төрийн намын үйл ажиллагаанд оролцдоггүй, улс төрийн нам, улс төрчдөд төлбөр хураамж төлдөггүй.**

**Бид улс төрийн үйл ажиллагаанд оролцдоггүй.** Групп нь шууд болон ууд бус байдлаар улс төрийн намын үйл ажиллагаанд оролцдоггүй, улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд төлбөр, хураамж төлдөггүй.

**Ажилтан нь зөвхөн өөрийн нөөц бололцоогоор улс төрд оролцож болно.** Групп нь Рио Тинтогийн санхүүжилт, эд хөрөнгө, нөөц бололцоо, цаг хугацаа, хүн хүчийг ашиглаагүй бол ажилтнууд, үндсэн гэрээлэгчдийг хувь хүн, иргэний хувьд улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглохгүй.

#### Рио Тинтогийн ажилтнуудад дараахийг хориглодог. Үүнд:

- Рио Тинтогийн санхүүжилт, эд хөрөнгө, нөөц бололцоо, хүн хүчийг, тэр дундаа мөнгөн бус хэлбэрээр хангамж, тоног төхөөрөмж, үйлчилгээг ашиглаж улс төрийн хандив тусламж үзүүлэх, аливаа улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд туслах;
- улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд төлбөр, хураамж төлөх, зээл, хандив, бэлэг сэлт өгөхөд Рио Тинтогийн санхүүжилтийг ашиглах;
- улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигч, тэднийг дэмжигчдийн зохион байгуулсан чуулга уулзалт, оройн зоог буюу ижил төстэй арга хэмжээнд оролцох төлбөр/хураамж төлөх, хөрөнгө босгох зорилгоор хэвлэн нийтлэгдсэн зүйлийг нь Рио Тинтогийн санхүүжилтээр худалдан авах;
- улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид, тэдгээрийн ажилтнуудыг энэ стандартад зааснаас өөр бусад байдлаар аялуулах, байраар хангах;
- улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд Рио Тинтогийн санхүүжилтээр хандив өгөх;
- Рио Тинтод ажиллах хугацаандаа, эсхүл Рио Тинтогийн санхүүжилт, эд хөрөнгө, нөөц бололцоо, хүн хүчийг ашиглаж байх хугацаандаа өөр бусад ажилтнууд болон үндсэн гэрээлэгчдийг шууд болон шууд бус байдлаар улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчдийг дэмжих, тэдний төлөө ажиллахыг санал болгох;
- аливаа улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн халхавч болсон, эсхүл тэдний санхүүжилтийг холбох арга хэрэгсэл болсон байгууллагад Рио Тинтогийн санхүүжилтээр төлбөр, хураамж төлөх.

**Төрийн албан хаагчийг томилохдоо болгоомжтой хандах.** Группын гүйцэтгэх удирдлагын зөвшөөрөлгүйгээр Групп нь дараахийг хийж болохгүй. Үүнд:

- улс төрч буюу төрийн албан хаагчийг зөвлөхөөр ажиллуулах;
- улс төрч буюу төрийн албан хаагчийг (буюу сүүлийн 12 сарын хугацаанд тэтгэвэртээ гарсан буюу ажлаасаа чөлөөлөгдсөн улс төрч буюу төрийн албан хаагч) компанидаа албан тушаалд томилох

#### ТАЙЛБАР:

АНУ дах улс төрийн үйл ажиллагааны хорооны талаар *Авилгалын эсрэг тэмцэх удирдамжид* тусгасан бий.

## 4.0 Буяны хандив, тэтгэлэг

**Рио Тинто нь хээл хахууль буюу бизнесийн зүй бус давуу талыг олж авах төлбөр гэж үзэх буяны хандив, тэтгэлэг олгодоггүй.**

### ТАЙЛБАР:

Энэ хэсгийн ямар ч заалт биднийг харилцан хүндлэл, эрчимтэй түншлэл, урт хугацааны үүрэг амлалтыг харуулсан бат бөх хөршийн харилцаа тогтоох зорилгоос ухраахгүй.

Тус хэсэгт дараах нэртөмьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

**Буяны хандив** гэдэг нь буяны байгууллага (их дээд сургууль гэх мэт боловсролын байгууллага хамаарна), буяны хандив тусламж, буяны өглөг, филантропийн үйл ажиллагаанд өгөх хандив тусламжийг хэлнэ.

**Хандив** гэдэг нь хариуд нь арилжаа худалдааны ашиг авах санаагүйгээр аливаа байгууллага (буяны буюу өөр бусад), хувь хүнд сайн дураар өгөхийг дэмжсэн, өгөх санаа санаачлага гаргасан багахан эсхүл үлэмж хэмжээний нөөц, баялгийг (цаг хугацаа, санхүү, эд хөрөнгө буюу хүн хүчний) хэлнэ. Хандив нь арилжаа худалдааны ашиг орлого авчирдаг ивээн тэтгэлгээс ялгаатай.

**Ивээн тэтгэлэг** гэдэг нь тодорхой эрх, урамшуулал, түүнтэй адил ашиглаж болох зүйлийн хариуд санхүү, эд хөрөнгө, өөр бусад нөөц бололцоог олгох замаар арга хэмжээ, санал, санаачлага болон байгууллагад (их, дээд сургууль гэх мэт боловсролын байгууллага багтана) үзүүлэх дэмжлэгийг хэлнэ. Ивээн тэтгэлгийн хамрах хүрээ их бага байж болох бөгөөд харилцан ашигтай байх зорилгоор олгоно. Ивээн тэтгэлгийг нэг удаагийн хөрөнгө оруулалтаар олгох эсхүл урт хугацааны үүрэг хариуцлагын хэлбэрээр олгож болдог. Группийн нэр хүндийг өсгөх, олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа сурталчлах зорилгоор тухайн улс оронд дотоодод нь ивээн тэтгэлэг олгож болно.

**Шударга бус давуу эрх олох зорилгоор буяны хандив, ивээн тэтгэлэг олгохгүй.** Буяны хандив, ивээн тэтгэлгийг хуульд заасан зориулалтаар олгох бөгөөд хээл хахуулийн халхавч болгохыг хориглоно.

**Буяны хандив, тусламжийг хувь хүнд өгөхийг хориглоно.** Групп нь буяны хандив тусламжийг (болон холбогдох төлбөрийг) зөвхөн байгууллагын бүтэц зохион байгуулалтад орсон олон нийтийн бүлэг, клуб, холбоо, нийгэмлэг, ашгийн бус байгууллага, төрийн бус байгууллага, олон нийттэй холбоотой өөр бусад арилжааны байгууллага, их, дээд сургууль зэрэг боловсролын байгууллагад олгоно.

**Улс төртэй холбоотой буяны хандив тусламж, ивээн тэтгэлэг олгохыг хориглоно.** Групп нь улс төрийн нам, улс төрийн зүтгэлтэнтэй холбоотой байгууллагад буяны хандив өгөхгүй, тийм байгууллагыг ивээн тэтгэхгүй.

Буяны хандив тусламж, ивээн тэтгэлэг нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрсөн байх;
- Группын санхүүгийн бүртгэл тооцоонд үнэн зөвөөр туссан байх;
- буяны буюу олон нийтийн зорилгоор хийгдсэн байх;
- С буюу түүнээс дээгүүрх зэргийн (ерөнхий захирал/ерөнхийлөгч) албан тушаалтнаар урьдаар батлуулсан байх

Байгууллагатай хийсэн гэрээнд ивээн тэтгэлгийг ил тод байдлаар баримтжуулах ёстой.

## 5.0 Хээл хахууль, авилга, зөрчлийг мэдээлэх нь

**Рио Тинтогийн ажилтан бүр тус стандартын зөрчлийн талаар мэдээлэх үүрэгтэй.<sup>2</sup>**

Тус хэсэгт дараах нэртомьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

Анхааруулга/сэрэмжлүүлэг гэдэг нь хээл хахууль эсхүл энэ стандарт, Бидний ажилладаг арга барил, агент, зөвлөх, гэрээлэгчийн бизнесийн ёс зүй, Рио Тинтотой байгуулсан түншлэлийн гэрээ зэргийн зөрчлийн талаарх аливаа баримт нотолгоог хэлнэ.

**Сонор сэрэмжтэй байж, мэдээл.** Рио Тинтогийн ажилтан нь хээл хахууль, авилгатай холбоотой анхааруулга/сэрэмжлүүлэгт анхааралтай хандаж, ийм сэрэмжлүүлэг/анхааруулгын талаар шууд удирддаг менежер буюу түүнээс дээшхи албан тушаалтанд мэдэгдэх ёстой.

**Хууль, дүрмийн хэрэгжилтийг хангахад мэдээлэл амин чухал юм.** Тус стандартыг зөрчиж болзошгүй үйлдлийн талаар мэдэж байгаа, санаа зовниж байгаа эсхүл сэжиглэж байгаа бол энэ асуудлыг шууд удирддаг менежертээ мэдэгдэх ёстой. Холбогдох менежертээ асуудлыг мэдэгдэх нь зохисгүй гэж үзвэл та өөрөөсөө өндөр албан тушаалтай удирдлагын багийн өөр албан тушаалтанд мэдэгдэж болно. Мэдээлэл хүлээж авсан хүн тус асуудлыг тухайн нэгжийн хамгийн дээд удирдлагад мэдэгдэх ёстой.

**Таныг хууль бус үйл ажиллагаанд оролцохыг хүссэн бол заавал мэдээл.** Рио Тинтогийн дараах ажилтнууд дараах асуудлын талаар холбогдох менежертээ нэн даруй мэдээлэх ёстой. Үүнд:

- хээл хахууль, авилгатай холбоотой үйл ажиллагаанд оролцохыг шууд болон шууд бус байдлаар танд санал болгосон бол,
- хээл хахууль, авилгатай холбоотой үйл ажиллагаанд сэжиглэсэн бол,

Дараахийг санаж байх хэрэгтэй. Үүнд:

Та:

- менежертээ, эсхүл ахлах ажилтантайгаа ярилц – эхлээд эдгээр хүмүүст хандах хэрэгтэй; эсхүл
- Рио Тинтогийн Эрхзүйн албатай холбогд; эсхүл
- манай *Speak-OUT* буюу санал гомдлоо нээлттэй мэдээлэх програмыг ашигла.

Дэлгэрэнгүй мэдээллийг Авилгалын эсрэг тэмцэх удирдамжаас үзнэ үү.

## В ХЭСЭГ– Группын бизнесийн менежментийн цаашдын асуудал

### 6.0 Удирдах түвшинд мэдээлэх, мөрдөн шалгах

**Сэжигтэй зөрчлийг мөрдөн шалгах болно.**

**Асуудал гарахад зөв хүмүүст мэдээлэх.**

Рио Тинтогийн ажилтны мэдээлсэн асуудлыг менежер дээд шат тус бүртээ мэдээлэх явцыг Группээс хангана. Менежерүүд нь тус стандартын зөрчлийн талаарх сэжиг, завдалт, мэдээлэл, гарсан тохиолдлыг залилан гэж үзэн мэдээлэх ёстой – Залилангийн эсрэг мөрдөх хэм хэмжээний 3.3.1 дэх хэсгийг үзнэ үү. Түүнчлэн, Группын зүгээс дотоод хяналтыг ноцтойгоор зөрчсөн гэж үзвэл тухайн асуудлыг Эрхзүйн албаны дарга, Компанийн хяналтын албаны даргад нэн даруй мэдэгдэнэ – Залилангийн эсрэг мөрдөх хэм хэмжээний 3.3.1 дэх хэсгийг үзнэ үү.

**Группээс мөрдөн шалгах.** Групп нь эдгээр бүх асуудлын талаар мөрдөн шалгах ёстой – Рио Тинтогийн Эрх зүйн даган мөрдөх стандартын 4.1.4-4.1.13 дах хэсэг, Ноцтой буруу үйлдлийн талаарх мэдэгдлийг мөрдөн шалгах стандартыг үзнэ үү.

## 7.0 Группын бүртгэл, тооцоо, дотоод хяналт

### Рио Тинтогийн бүртгэл, тооцоо үнэн зөв байх ёстой.

Төлбөрийг үргэлж үнэн зөв, ил тод байдлаар бүртгэн тэмдэглэх. Групп нь дотоод хяналтын үр дүнтэй систем, тэр дундаа санхүү, нягтлан бодох бүртгэл, татварын тайлан тооцооны бүртгэлтэй байж, бизнесийн харилцаанд эдгээр тайлан, бүртгэл, тооцоог үнэн зөв хөтөлж, дараахиас урьдчилан сэргийлнэ. Үүнд:

- хээл хахууль, авилга;
- бүртгэгдээгүй, тодорхойгүй, нууц бүртгэл тооцоо;
- холбогдох гүйлгээг зүй ёсоор, үнэн зөвөөр бүртгээгүй буюу бүртгэх ёстой гүйлгээг орхигдуулсан бүртгэл тооцоо.

Удирдлага нь хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Шууд удирдлага нь тус стандартын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг олж тогтооход зохих дотоод хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Залилангийн эсрэг мөрдөх хэм хэмжээний 3.4.1 хэсэг энэ стандартад хамаарна.

Шинэ улсад, шинэ төсөлд үргэлж авилгын эрсдэлийг тооцож байх. Нэрлэсэн улсад аливаа шинэ төсөл, үйл ажиллагаа эхлэхээсээ өмнө Групп нь бизнесийн ёс зүйн зарчим болоод тус стандартад заасан асуудлуудад онцгойлон анхаарч хууль, дүрмийн хэрэгжилтийн эрсдэлийн үнэлгээ хийх ёстой. Эрсдэлийн үнэлгээг баримтжуулах ёстой – Эрх зүйн даган мөрдөх стандартын 2.1 дэх хэсгийг үзнэ үү.

#### ТАЙЛБАР:

Нэрлэсэн улс гэдэг нь тодорхойлсон нэр томъёо юм.

Алдагдал, торгуулийн төлбөрийг дотооддоо төлдөг. Энэ стандартыг зөрчсөний улмаас үүссэн алдагдлыг тухайн үйл явдлын хамаарах төвийн ашиг / зардалд хамааруулна.

Авилгын хяналтын системийг байнга хэлэлцэж, хянан шинэчилж байх. Групп нь аудит явуулахдаа хээл хахууль, авилга зэрэг бизнесийн ёс зүйн асуудлыг авч үзэх ёстой.

## 8.0 Эрх зүйн зөрчлийн эрсдэлийг бууруулах сургалт

### Авилгад өртөх эрсдэл өндөртэй албан тушаалд ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлагын ажилтнууд тус стандартыг зөрчих эрсдэлийг бууруулах үүднээс сургалтанд хамрагдсан байх шаардлагатай.

Тус хэсэгт дараах нэртөмьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

**Эрх бүхий албан тушаалтан** гэдэг нь тус Эрх зүйн даган мөрдөх стандартад заасан утгыг илэрхийлнэ.

**Авилгад өртөх эрсдэл өндөртэй албан тушаалтан** гэдэгт дараах багтана. Үүнд:

- а) ажилдаа авилгын асуудалтай ихээхэн тулгарч болзошгүй Рио Тинтогийн бүх ажилтнууд, тухайлбал маркетингийн шийдвэр, хангамжийн шийдвэр, гаалийн бүрдүүлэлт, бизнес/томоохон эд хөрөнгө худалдан авах, худалдах шийдвэрт оролцдог албан тушаалтнууд, хуулийн зөвлөх, өмнө нь харилцаж байгаагүй хууль эрх зүйн байгууллагатай харьцаж ажиллах хайгуул судалгааны багийн гишүүд багтах бөгөөд эдгээр ажил үүрэг нь нэрлэсэн улсад байрласан, холбогдсон байна.
- б) дээрх Рио Тинтогийн ажилтнуудын шууд удирдлага;
- с) Байрлал, албан тушаал харгалзахгүй С буюу түүнээс дээшхи зэргийн бүх албан тушаалтнууд.

#### ТАЙЛБАР:

Нэрлэсэн улс гэдэг нь тодорхойлсон нэртөмьёо юм.

Групп бүр дараах зүйлсийг хийх ёстой. Үүнд:

- а) Эрсдэлийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эрх бүхий албан тушаалыг тодорхойлж, тэдгээр албан тушаалыг хаших ажилтнууд, үндсэн гэрээлэгчдийг тодорхойл. Залилангийн эсрэг мөрдөх хэм хэмжээний 3.5.1 хэсэг энэ стандартад хамаарна. (эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан онлайн сургалт мөн хамаарна);
- б) Эрх бүхий албан тушаалын аль нь авилгад өртөмтгий албан тушаал болохыг тогтоох;
- с) Авилгад өртөмтгий эрх бүхий албан тушаалтнуудад Рио Тинтогийн Эрх зүйн албаны зааварлагчтай авилгатай тэмцэх сургалт явуулна (шаардлагатай давтамжтайгаар – Эрх зүйн даган мөрдөх стандартын 3.1.4 - 3.1.8 дах хэсгүүдийг үзнэ үү);
- д) Нэрлэсэн улсад шилжин ирсэн аливаа ажилтан, үндсэн гэрээлэгчийг тухайн улсад ирэхээс нь өмнө Рио Тинтогийн Эрхзүйн албанаас зааварлагчтай, авилгатай тэмцэх сургалтад хамруулна;

## 8.0 Эрсдэлийг бууруулах сургалт (үргэлжлэл)

- е) Дараах байдлыг хангаж ажиллана. Үүнд:
- i. Авлигад өртөх эрсдэл өндөртэй албан тушаалтнуудад зориулсан авилгын эсрэг мэдлэг олгох сургалтын мэдээллийг Мэдээллийн нэгдсэн сан (Эрх зүйн талаарх хуудас)-д оруулдаг;
  - ii. Мэдээллийн нэгдсэн сан (Эрх зүйн талаарх хуудас)- дах Авлигатай тэмцэх хуудсанд заасан журмын дагуу дээрх албан тушаал хашдаг ажилтнууд, үндсэн гэрээлэгчдийн шинэчилсэн мэдээллийг хөтөлж, Рио Тинтогийн Эрх зүйн Албанд өгдөг.

## 9.0 Бизнесийн түншлэлийн харилцаа

**Рио Тинто нь хувьцааг нь эзэмшдэг бүх бизнесийн үйл ажиллагаандаа ижил төстэй авилгатай тэмцэх стандартыг нэвтрүүлж, мөрдөнө.**

Тус хэсэгт дараах нэртөмьёог доорхи утгаар ойлгоно. Үүнд:

**Рио Тинтогийн Бизнесийн ёс зүйн даган мөрдөх стандарт** гэдэгт *Бидний ажилладаг арга барил*, энэ стандарт, *Бизнесийн ёс зүйн (ашиг сонирхлын зөрчил) стандарт*, *Гуравдагч талын заавал мөрдөх ёс зүйн стандарт* зэргийг хамруулан авч үзнэ.

### 9.1 Групп бүр дараахийг хийх ёстой. Үүнд:

- Рио Тинтог группэд хамаарах бүх бизнесийн үйл ажиллагаанд Рио Тинтогийн бизнесийн ёс зүйн стандартыг нэвтрүүлж, дагаж мөрдөх;
- шинээр авсан, дийлэнхи хувьцааг эзэмшдэг аж ахуйн нэгжийн/ түншлэлийн хувьд:
  - гэрээний баримт бичигт түнш Группыг Рио Тинтогийн бизнесийн ёсзүйн стандартыг нэвтрүүлж, мөрдөх шаардлага тавьсан зүйл, заалт (Авилгалын эсрэг хуудасны Эрхзүйн багц дах зүйл заалттай ижил төстэй) оруулах;
  - Рио Тинтогийн бизнесийн ёс зүйн стандарт, гэрээний зүйл заалтыг бүх түнш Группэд даган мөрдүүлэх.

Ийм зүйл заалтыг гэрээний баримт бичигт тусгах боломжгүй бол:

- Группын гүйцэтгэх удирдлага, Эрх зүйн албаны дарга нар гэрээний баримт бичигт тусгах заалтын маягтыг батлана.

- гэрээний баримт бичигт оруулах заалтыг баталдаг этгээд (ТУЗ, хөрөнгө оруулалтын зөвлөл гэх мэт) энэ талаар зөвлөмж авсан байх ёстой

Гэрээний зохицуулалтгүй бол (зах зээлээс компанийг худалдан авсан гэх мэт):

- Группын гүйцэтгэх удирдлага, Эрх зүйн албаны дарга нар Рио Тинтогийн ёс зүйн стандартыг нэвтрүүлэх, дагаж мөрдөх хугацааг тогтоосон ажлын төлөвлөгөөг батална.

## 9.0 Бизнесийн түншлэлийн харилцаа (үргэлжлэл)

### 9.2 Групп цөөнхи хувьцааг эзэмшдэг буюу

Рио Тинто удирдан явуулаагүй аливаа шинэ түншлэлийн хувьд Групп бүр дараахийг хийх ёстой. Үүнд:

- Рио Тинтогийн бизнесийн ёс зүйн стандарттай ижил төстэй зарчим, стандартыг нэвтрүүлж, дагаж мөрдөхийг түнш компаниас шаардсан зүйл, заалтыг гэрээний баримт бичигт (Авилгатай тэмцэх портал дах зүйл заалттай ижил төстэй) тусгуулахыг эрэлхийлэх;
- гэрээний баримт бичигт ийм зүйл заалт оруулах боломжгүй бол,
  - Группын гүйцэтгэх удирдлага, Эрхзүйн албаны дарга нар гэрээний баримт бичигт тусгах заалтын маягтыг батална;
  - гэрээний баримт бичигт оруулах заалтыг баталдаг этгээд (ТУЗ, хөрөнгө оруулалтын зөвлөл гэх мэт) энэ талаарх гэрээний байр суурийн зөвлөмжөөр хангагдах ёстой;
  - Удирдах үүрэгтэй оролцож буй түнш, түншлэлд хяналт тавьж, авилгын эрсдэл нэмэгдсэн байдал буюу гэрээний баримт бичгийн зүйл, заалтын зөрчлийн талаар мэдэгдэх.

#### Хянан засварласан тухай тэмдэглэл

##### Хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн:

Рио Тинтогийн гүйцэтгэх удирдлага

##### Баримт бичгийг эзэмшигч:

Рио Тинтогийн Эрх зүйн хэлтэс

#### Хянан засварласан тухай тэмдэглэл

Хувилбарын дугаар	Гаргасан огноо	Нэмэлт өөрчлөлтийн утга	Нэрийн товчлол
Бизнесийн ёс зүйн даган мөрдөх удирдамж	2005		
Бизнесийн ёс зүйн (Авилгатай тэмцэх) даган мөрдөх стандарт	2012 оны 1-р сарын 01	Шинэ стандарт	ШС

#### Rio Tinto plc

2 Eastbourne Terrace  
London W2 6LG  
United Kingdom

T +44 (0)20 7781 2000

#### Rio Tinto Limited

120 Collins Street  
Melbourne, Victoria 3000  
Australia

T +61 (0)3 9283 3333